



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 09 дугаар сарын 21 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот

Хүүхдийн "Итгэл" төвийг татан буулгаж, "Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байр", "Хүүхдийн сургалт-үйлдвэрлэл-халамжийн төв" байгуулах тухай

Нэг.Хүүхдийн "Итгэл" төв нь ахуй амьдралын гачигдалтай, эцэг эх, гэр орноосоо хөндийрсөн хүүхдэд туслах, тэднийг асран хамгаалж, амьдрал хөдөлмөрт бэлтгэх, гэмт хараг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хангалтгүй ажиллаж, үнцсэн үүрэг зорилгоо хэрэгжүүлж чадахгүй байгааг үндэслэн "Итгэл" төвийг 1995 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Хоёр.Ахуй амьдралын гачигдалтай, эцэг эх, гэр орноосоо хөндийрсөн, хүмүүшлийн доголдолтой хүүхдэд туслах, тэднийг асран хамгаалах үйл ажиллагааг сайжруулах, энэ ажлыг төрөлжүүлэн зохион байгуулах, "Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай" Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор гэр орноосоо дайжсан, хаягдсан, төөрсөн хүүхдэд үйлчлэх "Хаяг тогтоох, шалган хуваарилах байр"-ыг Нийслэлийн цагдаагийн газрын харьяанд байгуулсугай.

Гурав."Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байр"-наас нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай нь тогтоогдсон хүүхдийг эцэг эх, гэр бүлтэй нь холбож ерөнхий боловсрол, ажил мэргэжлийн баримжаа олгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах үүрэг бүхий "Хүүхдийн сургалт-үйлдвэрлэл-халамжийн төв"-ийг Нийслэлийн Хүүхдийн төлөө Төвийн харьяанд байгуулан ажиллуулсугай.

Дөрөв."Хүүхдийн сургалт-үйлдвэрлэл-халамжийн төв"-ийн дүрэм, "Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байр"-ын түр дүрмийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Тав.Хүүхэд сургууль завсардах, гэр бүлээсээ дайжих шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээг гэр бүл, эцэг эхтэй нь холбон хэрэгжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

2.

✓ Зургаа. Сургууль завсардсан, гуламжинд тэнүүчлэн амьдарч байгаа хүүхдийг хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэгт сургаж хүмүүжүүлэх, халамж тусалцаа үзүүлэх арга хэмжээ авахыг Нийслэлийн боловсролын газар /П.Дорж/, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

✓ Долоо. "Эцэг ах, гэр орноосоо хөндийрсөн, гадуур тэнүүчлэн амьдардаг, нийгмийн халамж шаардлагатай хүүхдийн талаар авах арга хэмжээний бэсрэг хөтөлбөр"-ийг энэ оны 10 дугаар сард багтаан боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэхийг Тамгын газар /Ц.Болдсайхан/, Цагдаагийн газар /Ч.Амарболд/, Эрүүл мэндийн газар /Г.Буян-Өлзий/, Боловсролын газар /П.Дорж/, Хүүхдийн төлөө төв /С.Ширчмаа/-г үүрэг болгосугай.

Найм. Хүүхдийн "Итгэл" төвийн эзэмшиж байсан барилга байгууламж, үндсэн хөрөнгийг Нийслэлийн Хүүхдийн төлөө төвийн бэлэнсад, харьяа цэцэрлэгийн барилга байгууламж, үндсэн хөрөнгийг Нийслэлийн Цагдаагийн газрын балансад тус тус шалгуулсугай.

Ес. "Хүүхдийн сургалт-үйлдвэрлэл-халамжийн төв", "Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байр"-ыг нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/, Дүүргүүдийн Засаг дарга нарт зөвшөөрсугай.

✓ Арван. Хүүхдийн "Итгэл" төвд байрлаж байгаа ая ахуйн нэгж, айд өрхийг энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор нүүдсэн байрыг сулдуулж, барилга байгууламж, үндсэн хөрөнгийг хүлээцүүлэх йжлыг зохион байгуулахыг Тамгын газар /Ц.Болдсайхан/, Цагдаагийн газар /Ч.Амарболд/, Хүүхдийн төлөө төв /С.Ширчмаа/, Баянгол дүүргийн Засаг дарга /н.Хулганмаа/, "Итгэл" төвийн захирал /Х.Баавгай/ нарт даалгасугай.

✓ Арваннэг. "Хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах байр"-ын сантехник болон барилгын засварт шаардагдах хөрөнгийг 1996 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж санхүүжүүлэхийг Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс /Ч.Бат/, Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/-г зөвшөөрсугай.

3.

Арванхоёр.Энэхүү захирамж гарсантай холболдуулан Хүүхдийн "Итгэл" төв байгуулах тухай" Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 62, "Хүүхдийн "Итгэл" төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1992 оны 155 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЦАГТА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.Баасанжав

Ц.БААСАНЖАВ